



Санхүү Эдийн Засгийн
Т Е Х Н И К У М

LV

1924—1979

БНМАУ-ЫН САНГИЙН ЯАМНЫ ХАРБЯА
САНХҮҮ-ЭДИЙН ЗАСГИЙН
ТЕХЧИКУМ

Санхүү-эдийн засгийн техникум 1924 оны 6-р сарын 1-ний өдөр Сангийн яамны дэргэд "Гаалийн нягтлан бодохын түр сургууль" гэдэг нэртэй 40 сурагч 2 багштайгаар байгуулагдсанаас хойш 55 жил боллоо.]

Нягтлан бодогчийн түр сургууль 1935 онд санхүүгийн техникум болгон өргөтгөж, үйлдвэр, төсөв, санхүү, банкны байгууллагуудад ажиллах нягтлан бодох бүртгэл, санхүүгийн дунд мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх болгож, сурагчдын тоог 150 хүртэл нэмэгдүүлэн, сургуульд заах хичээлийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 49-р хурлын тогтоолоор Санхүүгийн техникумыг Санхүү-эдийн засгийн техникум болгон өргөтгөж суралцах хугацааг 3 жил, сурагчдын тоог 375 болгож сургалт, мэргэжил эзэмшүүлэх ажлын чанарыг сайжруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр заажээ.

Техникумд 4-7 жилийн боловсролтой хүмүүсийг элсүүлэн авч, төгсөгчдийн мэдлэг, улс төрийн боловсролыг дээшлүүлэх талаар анхаарч нийгмийн ухааны ба мэргэжлийн зарим хичээлүүдийг нэмж заах болжээ.

1956 оноос хойш тус сургуулийн сургалтын төлөвлөгөөг улам сайжруулж төгсөгчдөд олгох ерөнхий боловсрол эдийн засгийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорчгоор улс төрийн эдийн засгийн ухаан, нийгэм судлал, санхүү зөөл, нягтлан бодох бүртгэл, үйлдвэрлэлийн технологи, санхүүгийн хяналт шалгалт, хөгжмийн мэдэгдэхүүн зэрэг хичээлүүдийг цагийн талаар нэмэгдүүлж заадаг болсноос гадна сургалтыг амьдралтай холбох, сурагчдын бие бялдар гоо сайхны хүмүүжлийг улам дээшлүүлэх ажил системтэй зохиогдож эхэлсэн байна.

└ Нам засгаас авч хэрэгжүүлсэн эцрээр арга хэмжээнүүдийн үр дүнд төгсөгчид Санхүү-эдийн засгийн дунд мэргэжил эзэмшиж улс ардын аж ахуйн хэрэгцээт газар байгууллага бүхэнд мэргэжлийн ажлаа хийх, их дээд сургуульд суралцах зохих бэлтгэлтэй сургуулиа төгсөх болсон юм.┘

└ Улс ардын аж ахуй соёлын хөгжлийн хурдац нь бүртгэл тооцооны мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх зүй ёсны шаардлага тавих болсноос 1972 оноос эхлэн тус сургуулийн элсэлтийг 10-р анги төгссөн хүмүүсээр хангах болж сургалтын шинэ систем мөрдөж мэргэжлийн хичээл үзэх цагийг нэмэгдүүлэн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг улам боловсронгуй болгож шинэчлэн баталж мөрдүүлээ.┘

Тус сургууль 1967 оноос эхлэн оройн

ангитай, 1972 оноос эхлэн Хөдөө аж ахуйн нэгдлийн нягтлан бодох мэргэжлээр жил бүр чинээ ангид элсэлт авдаг боллоо.

55 жилийн дотор Аж үйлдвэрийн нягтлан бодогч 2933, барилга, тээврийн нягтлан бодогч 1719, ХАА-н нягтлан бодогч 3068, Санхүү-төсөв, Банкны байгууллагын нягтлан бодогч 3973, хяналт шалгалт, статистикийн мэргэжлээр 564 бүгд 12857 хүнийг бүртгэл тооцсоны дэрэгжил эзэмшүүлэн улс ардын аж ахуй соёлын бүх салбарт шилжүүлэн ажиллуулжээ.

Тус сургууль материаллаг оазчин талаар бэхжиж хичээлийн ба 300 сурагчид суух дотуур байр, биеийн тамирын заалтай 10 кабинеттай, 28 гаруй мянган нэр төрлийн номтой тохилог номын сан, нэг ээлжинд 80 хүн суух уншлагын заалтай, бүрэн дээд боловсролтой бэлтгэх хүчнээр хангагдаж 1978, 1979 оны хичээлийн жилээс анги кабинетын системээр хичээллэж сургалтын материаллаг базыг бэхжүүлэхэд улам их анхаарал тавьж байна.

Тус сургуулийн сурагчдын дотор төрөл бүрийн сонгон суралцах хичээлүүд тусгай хуваариар явагддаг ба энэ хичээлийн жил урлаг, биеийн тамир спортын 16 секцэд 500 гаруй сурагчид хамрагдаж байна.

Манай сургууль үйлдвэр, барилга, тээвэр, Сангийн аж ахуй, Хөдөө аж ахуйн нэгдэл, Хяналт шалгалт, Статистик, Санхүү төсөв, Банкны нягтлан бодогч 9 мэргэжлээр төгсгөж байгаа-

гаас гадна төгсөгчид нийгмийн ухааны хичээлийг нилгэд өргөн программаар судлууддаг болсон нь дээд сургуульд суралцах бэлтгэлийг хангахад ихээхэн ач холбогдолтой юм.

Санхүү-Эдийн засгийн техникумыг бүртгэл, эдийн засгийн дунд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэн гаргах үүргээ амжилттай биелүүлж ирснийг нам засаг өндрөөр үнэлж БНМАУ-ын хөдөлмөрийг гавъяачы улаан тугийн одон, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын СнЗ-ийн үүрд хадгалагдах туг, БНМАУ-ын СнЗ-ийн хүндэтгэх жуух бичгээр 2 удаа тус тус шагнасан юм.

Санхүү-эдийн засгийн техникум төгсөж гарсан олон мянган боловсон хүчин тус улсын нам төрийн дээд ба эдийн засгийн удирдах төв байгууллага, улс ардын аж ахуй, соёлын бүх байгууллагад үр бүтээлтэй ажиллаж байна.

Тус сургууль төгсөгчдийн дотор МАХН-ын Төв Хорооны улс төрийн товчооны гишүүн Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Д.Моломжавц, Намыч Төв хорооны нарийн бичгийн дарга П.Дамди, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Улсын төлөвлөгөөний комиссын дарга Д.Содном, БНМАУ-ын Яамдын сайд: Ц.Молом, Ё.Очир, О.Нямаа, Хөдөлмөр цалин хөлсний улсын хорооны дарга М.Лхамсүрэн, Увс аймгийн АДХГ Захиргааны дарга Г.Баасанжав зэрэг Яам тусгай газрын сайд дарга, орлогч сайд зэрэг удирдах ажилтнууд олон байна. Эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн 20 гаруй, Гавъяат

эдийн засагч 4, Санхүү-банкны тэргүүний
ажилтгач, соёл урлаг, утга зохиол, спортын
гавъяатнууд цөөн үй байна.]

Тус сургууль 55 жилийнхээ өнгө унтаж,
соёлч сургууль болох үүрэг аван ажиллаж,
социалист уралдааныг бүх багш ажилчид,
сурагчид анги бүлэг, байр тасгуудын хооронд
янз бүрийн хэлбэрээр зарлан явуулж байгаа-
гийн үр дүнд соёлч нөхөрлөлийн анги 8 төг-
сөж, сургуулиараа 1978 оны намрын ургац
хураалтын шилд 2-р байр эзлэн, сур-
гуулийн дотуур байр, соёлч тэргүүний байгуу-
лагын гэрчилгээ авлаа.

Манай хамт олон МА.Н-ын эдийн засгийн
бодлогыг хэрэгжүүлэх үйлсэд идэвхтэй орол-
цогч бүртгэл эдийн засгийн мэргэжилтэн
бэлтгэх ажлын чанарыг сайжруулахын тулд зориг
төгөлдөр хөдөлмөрлөж байна.]

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ТЕХНИКУМ

1979-06-15.

